

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМНЫ
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ХООРОНД
БАЙГУУЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ**

2026 оны 03 сар 09 өдөр

Дугаар 06/04/1...26/20

Улаанбаатар хот

Нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар /цаашид “ОБЕГ” гэх/ нөгөө талаас Зам тээврийн яамны Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /цаашид “Алба” гэх/, /цаашид хамтад нь талууд гэх/ хамтран ажиллах талаар дор дурдсан асуудлаар харилцан тохиролцож энэхүү санамж бичгийг байгуулав.

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Санамж бичгийн зорилго нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенц болон түүний 13 дугаар хавсралт, Гамшгаас хамгаалах тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Улсын нисэхийн тухай хуулийн хүрээнд хүний амь нас аврах ажиллагааг нэн тэргүүнд хэрэгжүүлэхийн зэрэгцээ, ослын шалтгааныг тогтоох, цаашид хүний амь нас, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2. Талууд хамтын ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 заалт, Иргэний нисэхийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 заалтыг хэрэгжүүлж, байгууллага хоорондын харилцааны зохистой хэмжээг баримтлах, харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, нээлттэй ил тод байдлыг хангах, үр бүтээлтэй хамтран ажиллах зарчмыг баримтална.

ХОЁР. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

2.1. Онцгой байдлын ерөнхий газар нь:

2.1.1. Иргэний агаарын хөлгийг эрэн хайх, авран туслах ажиллагааны “Ажиллагааны шуурхай штаб”-ыг байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах,

2.1.2. Осолд орсон агаарын хөлгийн маяг, зорчигчдын тоо, аюултай ачаа, үлдэгдэл шатахуун, ослын байршил, газар орон, цаг агаарын нөхцөл байдал, нисдэг тэргээр буулт хийх боломж болон бусад мэдээллийг судлах, нөхцөл байдлыг тодорхойлох,

2.1.3. Эрэн хайх, аврах ажиллагааны анги, бүлгийг томилж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн тусгай хувцас, хэрэгслээр ханган аюулгүй байдлыг хангах мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, холбоо, бүх төрлийн хангалтыг зохион байгуулж, эрэн хайх, аврах ажиллагааг эхлүүлэх, бэлтгэл болон нөөц бүлгийн бэлтгэх,

2.1.4. Агаарын хөлгийн ослын үед эрэн хайх аврах ажиллагааны анги, бүлэг ослын голомтод түрүүлж ирсэн үед нисэх баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах, голомтын хориотой бүс тогтоох,

2.1.5. Эрэн хайх аврах ажиллагааны анги, бүлэг нь хүний амь аврах, гал унтраахаас бусад тохиолдолд агаарын хөлөгт нэвтрэх буюу эд зүйлс оролдох, байрнаас нь хөдөлгөхгүй байлгах, эрх олгогдоогүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх,

2.2. Алба нь:

2.2.1. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 13-р хавсралтад заасны дагуу агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааг хараат бус, бие даан гүйцэтгэнэ.

2.2.2. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 13-р хавсралт түүний 4 дүгээр бүлгийн дагуу агаарын хөлгийн ослын тухай хэлэлцэн тохирогч дараах улсуудад нэн даруй мэдэгдэнэ. Үүнд:

- Бүртгэсэн улс
- Ашиглагч улс
- Зохион бүтээгч улс
- Үйлдвэрлэсэн улс

2.2.3. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 13-р хавсралт түүний 5 дүгээр бүлгийн дагуу дараах ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

-Ослын талаарх цуглуулсан, бүртгэсэн холбогдох бүх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, сонгогдсон мэдээллийг хамгаалах;

-Ослын газарт эвдэрсэн агаарын хөлөг түүний эд ангид үзлэг, шалгалт хийх, эд мөрийн нотлох баримтыг цуглуулах, хамгаалалтад авах;

-Ослын талаар цуглуулсан сонгогдсон бодит мэдээлэл, нотлох баримтуудад дүн шинжилгээ хийж шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоож дүгнэлт, тайлан болон аюулгүй байдлын зөвлөмж гаргах;

2.2.4. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 13 хавсралт түүний 7 дүгээр бүлгийн дагуу агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгаж гүйцэтгэсэн ажлын тайлан болон аюулгүй байдлын зөвлөмжийг холбогдох байгууллага болон дараах хэлэлцэн тохирогч дараах улсад илгээнэ. Үүнд:

- Бүртгэсэн улс
- Ашиглагч улс
- Зохион бүтээгч улс
- Үйлдвэрлэсэн улс

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА

3.1. Талууд нь агаарын хөлгийн ослын талаар мэдээлэл авсан нь харилцан бие биедээ нэн даруй мэдэгдэнэ.

3.2. Талууд агаарын хөлгийн ослын газрын бүс болон хамгаалалтыг тогтоох ажиллагааг хамтран шийдвэрлэнэ.

3.3. Талууд агаарын хөлгийн ослын газар дээрх аюулгүй ажиллагааны талаар хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.4. Талууд агаарын хөлгийн ослын газарт тус тусын чиг үүргийн дагуу ажиллах бөгөөд эд мөрийн баримтыг гэмтээхгүй, хүний амь нас аврахаас бусад тохиолдолд хөдөлгөхгүй байх, хамгаалалтад авах,

3.5. Талууд агаарын хөлгийн ослын үед хамтран ажиллах сургалт, дадлагыг зохион байгуулах энэ төрлийн олон улсын сургалт семинар болон бусад холбогдох арга хэмжээнд мэргэжилтнүүдээ оролцуулж, харилцан туршлага солилцох,

3.6. Талууд аврах ажиллагааны баг, шинжлэн шалгах баг болон олон улсын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг ослын газарт шуурхай хүргэх, нэвтрэхэд харилцан дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах,

3.7. Талууд энэхүү санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцсон бөгөөд санамж бичигт тусгагдсан заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбогдон аливаа эрх зүйн хариуцлага хүлээхгүй болно.

3.8. Аль нэг талаас гаргасан хүсэлтийн дагуу талууд гарах зардлыг урьдчилан харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА

4.1. Харилцан ойлголцлын санамж бичгийн талаар Онцгой байдлын ерөнхий газар талаас хариуцах албан тушаалтан, хаяг, утас, цахим шуудан:

Ажиллагааны удирдлагын газрын Агаарын ажиллагааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /дэд хурандаа Д.Батсайхан/
Сүхбаатар дүүрэг, 6 хороо, Партизаны гудамж-6
Утас: (976-89087887) 11321860
Цахим шуудан: Bataa337af@gmail.com

4.2. Харилцан ойлголцлын санамж бичгийн талаар Зам тээврийн яамны Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны талаас харилцах албан тушаалтан, хаяг, утас, цахим шуудан:

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагч /Ч.Буянбадрах/
Буянт-Ухаа, ХУД 21-р хороо, Улаанбаатар хот 17120
Утас: (976-71) 285553,
Цахим шуудан: buyanbadrakh@aaib.gov.mn



ТАВ. САНАМЖ БИЧГИЙН ХУГАЦАА

5.1. Энэхүү санамж бичиг нь талуудын хамтын ажиллагааны зорилгын илэрхийлэл бөгөөд үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хууль, дүрэмд нийцүүлэн санамж бичгийг байгуулсан гэж талууд ойлгоно.

5.2. Энэхүү санамж бичигт талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш эхлэн гурван жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Санамж бичгийн хугацаа дуусгавар болсон тохиолдолд сунгах, эсэх талаар талууд санал гаргаагүй тохиолдолд анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

5.3. Энэхүү санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх эсхүл цуцлах тохиолдолд талууд саналаа албан бичгээр мэдэгдэж, харилцан санал солилцож шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү санамж бичгийг 2026 оны 03 дугаар сарын 01-ны өдөр монгол хэл дээр хоёр хувь үйлдсэн бөгөөд бичвэрүүд нэгэн адил хүчинтэй байна.

ОНЦГОЙ ГАЗРЫН ХОШУУЧ ГЕНЕРАЛ	БАЙДЛЫН	ЕРӨНХИЙ ДАРГА,	АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА
/..... 	Г. АРИУНБУЯН	/..... 	Ж. ЦОЛМОН

8112738 ШТЖ1492 9025011078